

ӨЛЗИЙТ, ХУЛД ЦАГААНДЭЛГЭР, ДЭРЭН СУМДЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗӨВЛӨН ТУСАЛСАН АЖЛЫН ТАЙЛАН

2023 оны 05 дугаар сарын 01

Мандалговь хот


Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан удирдамжийн дагуу Өлзийт, Хулд, Дэрэн, Цагаандэлгэр сумдын Засаг даргын Тамгын газар болон төсвийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцан зөвлөн туслах арга хэмжээг зохион байгууллаа.

Удирдамжийн дагуу дагуу дараах сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд:

- 1.Төлөвлөлт ба тайлагналтад анхаарах асуудал
- 2.Цахим ур чадварыг нэмэгдүүлэхэд анхаарах асуудал
- 3.Архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт

Сургалтад 4 сумын 65 албан хаагч хамрагдсан. Үүний 14 эрэгтэй буюу нийт хамрагдсан албан хаагчдын 21.4 хувь эрэгтэй албан хаагч байна.

Сургалтад хамрагдсан албан хаагчдыг сумдаар болон хүйсээр нь харуулбал:





Төрийн захиргааны удирдлагын хэлтсээс:

Сумдын байгууллагын удирдлагуудад аймгаас мэдээллийн технологийн талаар баримталж буй бодлого, 2023 оны хийж гүйцэтгэсэн ажил болон цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл хийж, сумдын өнгөрсөн хугацаанд цахим шилжилттэй холбоотой үйл ажиллагаанд гарсан алдаа дутагдалд дүгнэлт

хийж, цахим шилжилтийн үйл ажиллагаагаа хэрхэн үр дүнтэй зохион байгуулах талаар заавар зөвлөмж өглөө.

Төрийн байгууллагуудын дотоод удирдлагын ERP системийн ашиглалтыг сайжруулах чиглэлээр систем хариуцсан албан хаагчдад заавар, зөвлөмж өгч, системд хэрэглэгч нэмэх, цахим цаг бүртгэл, албан хэрэг хөтлөлтийн хэвийн үйл ажиллагаа болон албан хаагчдын бүртгэлийг газар дээр нь шийдвэрлэж ажиллалаа.


Цахим шилжилтийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, Хулд, Цагаандэлгэр, Дэрэн сумдад цахим албан бичиг боловсруулалтын сургалтын зохион байгуулснаар тоон гарын үсгээр баталгаажуулан цахим албан бичиг илгээдэг боллоо.



Сумдтай хамтран цахим албан балангыг шаардлагын дагуу бэлтгэн архивын ерөнхий газраар батлуулж, цахим албан бичиг боловсруулах боломжийг бүрдүүллээ.

Сумдад тулгамдаад байгаа байгууллагын дотоод сүлжээ, компьютер, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ явуулж байгууллага, албан хаагчдын ажиллах нөхцөл боломжоор хангалаа.

Аймгийн сайтад мэдээллийн ил тод байдлын мэдээллийг хэрхэн байршуулах талаар 4 сумын 98 албан хаагчид арга зүйн зөвлөгөө өгч мэдээллийг оруулсан.



Хууль эрх зүйн хэлтсийн хүрээнд:

Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарын боловсруулсан эрх зүйн сургалт, сурталчилгааны болон эрх зүйн хөтөч нарын ажлын төлөвлөлт, Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөлтийг үзэж арга зүйн заавар зөвлөгөө өгсөн.

Архив, бичиг хэргийн ажилтан нарт архив, албан хэрэг хөтлөлтийн талаар арга зүйн заавар зөвлөгөө өгч ажиллалаа.

Тус ажлын хүрээнд Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан албан хэрэг хөтлөлтийн бүртгэлүүдээс 9 төрлийн бүртгэлийг сум, сумаар нь бэлтгэн өгч яаж хөтөлж ажиллах талаар заавар өгсөн.

Сумдын харьяа байгууллагын ажилтан нарт баримт бичиг боловсруулахдаа цаасны хэмжээ стандарт болон компьютер принтерийн тохиргоог яаж тааруулах талаар арга зүйн заавар өгч, дадлага сургуулилт хийж тааруулж өглөө. Мөн журмын дагуу тус оны баримтыг хүлээж авсан эсэх бүртгэлүүдийг үйлдсэн эсэхийг үзэж арга зүйн зөвлөгөө өгсөн.

Сумдын баримт бичгийн архивын хадгалалт хамгаалалт ямар нөхцөлд байгаа, дүрэм журмын дагуу цэвэрлэгээ үйлчилгээ, чийг дулааны горимыг тэмдэглэж буй эсэхийг үзэж, арга зүйн заавар зөвлөгөө өгч ажилласан.

2023 онд Төрийн архивд баримтын бүрдүүлэлтэй Өлзийт, Хулд сумдын бичиг хэргийн ажилтан нарт E-document.gov.mn архивын системд баримтаа яаж оруулж холбох, баримт бичгээ яаж цахимжуулж талаар сургалт хийж, заавар өглөө.



Хяналт- шинжилгээ, үнэлгээний чиглэлээр:


Сумдын Засаг даргын Тамгын газрын болон төрийн байгууллагууд, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний боловсруулалт, тайлагналтад анхаарах асуудлын талаар арга зүйн зөвлөгөө өгч, төлөвлөлтийн чанарыг сайжруулсан.

Төсвийн байгууллагуудын төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, 2022 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлж өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Боловсролын чанар хүртээмжийг дэмжих жилийн хүрээний төлөвлөгөөний боловсруулалтын байдалтай танилцан төлөвлөгөөний боловсруулалтыг сайжруулах талаар 32 төрийн албан хаагчид арга зүйн зөвлөгөө өгсөн.

Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухайн жилийн төлөвлөгөөг төлөвлөсөн байдал, хэрэгжилтийн явцтай танилцаж, дутагдалтай болон анхаарах асуудлыг эрчимжүүлэхийг холбогдох ажилтнуудад чиглүүлж зөвлөмж өгсөн.

Аймгийн дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх тухайн жилийн төлөвлөлт болон сумдын Засаг даргын дэргэдэх салбар, зөвлөл, хороодын төлөвлөлт, үйл ажиллагаатай танилцан төлөвлөгөө гарган эзэнжүүлж, дотоод хяналтын хүрээнд хяналт тавьж ажиллахыг зөвлөсөн.

Сумын Засаг даргын орлогч болон багийн Засаг дарга нарын хамтран ажиллах гэрээний төлөвлөгөөтэй танилцан, ололттой ба дутагдалтай талыг ярилцан цаашид анхаарах асуудлаар зөвлөмж өгсөн.



ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС